



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/638

Есөнбулаг

Газар чөлөөлөх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 15.6 км хатуу хучилттай автозам, 640 суудалтай "Хантайшир-Эрдэм цогцолбор" сургууль, "Дулааны станц" төслийн ус, дулаан дамжуулах 1 болон 2 дугаар хэлхээний шугам сүлжээний трасст өртсөн объектыг чөлөөлж, төсөл арга хэмжээг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Аймгийн Засаг даргын Хөгжлийн бодлого хариуцсан орлогч

Гишүүдэд: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (зөвшилцсөнөөр)
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
Цагдаагийн газрын дарга
Есөнбулаг сумын Засаг дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын

2

газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Захиргаа, хуулийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Есөнбулаг сумын газрын даамал

2.Газар чөлөөлөлтийг магадлалаар батлагдсан зураг төслийн дагуу трасст өртсөн хашаа, объектыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор чөлөөлж, үр дүнг Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/531 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ